




2024 5-р сар

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

ИНФЛЯЦЫН ТҮВШИН 6.4 ХУВЬД ХҮРЧ БУУРЛАА.

- 4-р сард инфляц 6.4 хувьтай гарч өмнө оны мөн үеэс 4.9 функтээр буурсан нь сүүлийн гурван жилд анх удаа 7 хувиас доош гарсан үзүүлэлт боллоо. Цаашлаад инфляцын 30 хувийг бүрдүүлэх мах, гурил, сүүн бүтээгдэхүүний зуны саруудад буурах хандлагатай байдаг нь инфляцыг бууруулах нөлөөлөлтэй юм.
- Монгол Улсын эдийн засаг 2024 оны 1-р улиралд 7.8 хувьтай гарсан ба уул уурхайн салбар 15.2 хувиар өссөн байна. Харин зудын нөхцөл байдлаас шалтгаалан малын хорогдол нэмэгдсэнээр хөдөө аж ахуйн салбар 31 хувиар буурчээ.
- Дизель түлшний импорт өмнөх оноос 33 хувиар, 92, 95 бензиний импорт 41 хувиар өссөн нь нийт импорт 29 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн байна. Харин экспортын хувьд нүүрсний экспорт 2 хувиар буурснаар нийт экспорт 3 хувиар буурсан байна. Харин алтны экспорт 41 хувиар, зэс 4 хувиар өссөн байна. Импорт нэмэгдэж, экспорт буурснаар Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл өмнөх оноос 37.5 хувиар буурч, 1.5 сая ам.долларын ашигтай гарчээ.
- Оны эхний дөрвөн сарын байдлаар манай улсын экспортын 60 хувийг нүүрс эзэлж байна. Нүүрсний экспортын биет хэмжээ 28 хувиар өссөн ч үнэ өмнөх оноос 26 хувиар буурч, 114 ам.доллар болсон нь нүүрсний нийт экспорт 2 хувиар буурахад нөлөөлжээ.

ХНС-ЫН ХАНШ БА ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГ.

- ХНС 6 дахь удаагаа дараалан бодлогын хүүгээ 5.25-5.5 хувьд хэвээр үлдээв. Энэ нь инфляц таамаглаж байснаас өндөр байгаатай холбоотой байна. АНУ-ын инфляц 4-р сард 3.5 хувьтай гарсан ба зорилтот 2 хувийн түвшнээс өндөр хэвээр байгаа нь шатахуун, орон сууцны үнэ нэмэгдсэнтэй холбоотой. Цаашлаад шинжээчид 9-р сард ХНС-аас бодлогын хүүг бууруулах магадлал 70% гэж таамаглаж байна.

- Хятадын хөрөнгө оруулагчид үл хөдлөх хөрөнгө, цаашлаад хөрөнгийн зах зээлээс болгоомжилж байгаа тул 18 сар дараалан алт худалдаж авлаа. Энэ нь алтны үнийг түүхэн дээд хэмжээнд хүргэж, Монголын алтны экспортыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.
- Хятадын экспорт 4-р сард 1.5 хувиар, импорт 8.4 хувиар өссөн нь гол төлөв Зүүн Өмнөд Ази болон бусад хөгжиж буй орнуудын нөлөөгөөр нийт эрэлт өссөнийг харуулж байна.
- Хятадын засгийн газраас үл хөдлөх хөрөнгийн салбарын хямралыг давж гарахын тулд орон нутгуудын засаг захиргаануудад хоосон орон сууцнуудаа зарж, худалдан авагчдад хадгаламжийн хүү багатай, хямд үнэтэй орон сууц худалдан авах боломж бүрдүүлэхийг шаарджээ.

МОНГОЛБАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ 11 ХУВЬД ХҮРГЭЖ БУУРУУЛЛАА.

- 4-р сараас төрийн албан хаагчид болон тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн ч инфляцад үзүүлэх нөлөөлөл нь хүлээгдэж байснаас бага байгаа тул Монголбанк бодлогын хүүг 11 хувь хүртэл бууруулах шийдвэр 5-р сарын 13-нд гаргасан. Мөн түүнчлэн ирэх 2-3 сардаа инфляц өсөхгүй гэсэн хүлээлттэй байна.
- 2023 оны 8-р сараас эхлэн төгрөгийн ам.доллартой харьцах ханш чангарч байгаа ба 4-р сарын сүүлчийн байдлаар нэг ам.долларт 3,376.5 төгрөг байна.
- Монголбанк "Эрдэнэс Тавантолгой" болон "Эрдэнэт үйлдвэр"-ээс 500 тэрбум төгрөгийн ногдол ашиг хүлээн авсан бөгөөд энэ мөнгийг ипотекийн зээлд зарцуулахаар болсон байна.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024Q1	2023Q4	2023Q1	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	6,065	30,454	5,624	7.8%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M04	2024M03	2023M04	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам доллар	4,998	3,720	5,084	-1.7%
Зэс	сая ам доллар	872	638	840	3.8%
Нүүрс	сая ам доллар	2,988	2,213	3,062	-2.4%
Нийт импорт	сая ам доллар	-3,426	-2,414	-2,660	28.8%
Хэрэглээ	сая ам доллар	-986	-726	-779	26.6%
Түүхий эд	сая ам доллар	-304	-222	-255	19.5%
Хөрөнгө оруулалт	сая ам доллар	-1,393	-905	-1,061	31.2%
Шатахуун	сая ам доллар	-738	-557	-563	31.2%
Тэнцэл	сая ам доллар	1,572	1,306	2,423	-35.1%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	9,446	8,693	8,809	7.2%
Нүүрс	\$/тонн	137	138	201	-31.5%
Газрын тос	\$/баррель	89	85	84	6.5%
Алт	\$/трой унц	2,334	2,162	2,000	16.7%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	2,087	1,591	1,100	89.8%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	9,873	7,286	6,712	47.1%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	-7,786	-5,695	-5,613	38.7%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M04	2024M03	2023M04	
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	38,127	37,400	30,188	26.3%
ХҮИ (C2015)	индекс	144.0	142.9	135.3	6.4%
Бодлогын хүү	%	12.0%	12.0%	13.0%	-7.7%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,377	3,376	3,476	-2.8%
Төгрөгийн хадгаламж	%	11.4%	11.9%	10.8%	5.3%
Валютын хадгаламж	%	3.4%	3.2%	2.8%	18.9%
Төгрөгийн зээл	%	17.2%	17.0%	16.9%	1.4%
Валютын зээл	%	9.1%	10.7%	10.2%	-10.8%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам доллар	4,986	5,250	3,691	35.1%
Үнэт цаас	сая ам доллар	2,237	2,405	675	231.6%
Харилцах, хадгаламж	сая ам доллар	2,165	2,206	2,483	-12.8%
ОУВС-д байршуулсан хөрөнгө	сая ам доллар	7	7	7	-2.5%
Зээлжих тусгай эрх	сая ам доллар	100	100	119	-16.1%
Мөнгөжсөн алт	сая ам доллар	476	532	407	17.0%


БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ны өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ




Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ



Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ

Ө. Мөрөн

Цахим хаяг: murun_u@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Дархлан

Цахим хаяг: darkhlan@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.